



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 11/155

Номгон

Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн
үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх тухай


Иргэд, төрийн бус байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Шинэжинст сумын нутагт орших MV-021444 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч "Эрдэнэ Монгол" ХХК, MV-012728, MV-017057, MV-017060, MV-017061, MV-017062, MV-021487, MV-021488 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч "Сэкер ресорсус монголиа" ХХК болон тэдгээрийн туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүд, Баян-Овоо сумын нутагт орших MV-006720, MV-006907 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч "Наранмандал Энтерпрайзес" ХХК болон түүний туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа нь хүн амын эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, уурхай ашиглахтай холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартын хэрэгжилтийг хангаж байгаа эсэхэд хяналт, шалгалт хийх ажлыг 2025 оны 03 дугаар сарын 24-өөс 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн хооронд зохион байгуулсугай.

2.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт зохион байгуулсан ажлын үр дүн, цаашид авах арга хэмжээний саналыг 2025 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн дотор танилцуулахыг Ажлын хэсэг (Б.Наранбаяр)-т үүрэг болгосугай.


ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

625010453

W:\2025 ON\ZAKHIRAMJ\ЗАХИРАМЖ+++.DOCX1



.. משרד המשפטים - רשם (הרשמה) (הרשמה)

הרשמה היא הרשמה של הרשמה - 01-00 הרשמה היא הרשמה של הרשמה - 01-00 הרשמה היא הרשמה של הרשמה - 01-00

Аймгийн Засаг даргын 2025 оны 03 дугаар
сарын 24-ний өдрийн 01/25 дугаар
захирамжийн Дүгээр хавсралт

**АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ АЖЛЫН
ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Наранбаяр Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүд:

Э.Ганзориг Байгаль орчны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

М.Магвансүрэн Аймгийн Засаг даргын Тамгын газрын Авто, зам тээврийн хяналтын Улсын ахлах байцаагч

Ц.Болорчимэг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Геологи, уул уурхай, газрын тос, хийн хяналтын Улсын ахлах байцаагч

Б.Намуун Аймгийн Засаг даргын Тамгын газрын Байгаль орчин, газрын харилцаа, уул уурхай бодлого хариуцсан мэргэжилтэн

Ц.Урангоо Эрүүл мэндийн газрын Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын Улсын ахлах байцаагч

Д.Баасанцэрэн Эрүүл мэндийн газрын Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын Улсын байцаагч

Ч.Жавзандулам Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүнсний чанар, стандартын хяналтын Улсын байцаагч

Ц.Уянга Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Байгаль орчин, газар, геодези зураг зүйн хяналтын Улсын байцаагч

Л.Намжилмаа Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөрийн хяналтын Улсын байцаагч

Г.Гантуяа Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөрийн хяналтын Улсын байцаагч

Д.Амарсайхан Нийгмийн даатгалын газрын Нийгмийн хамгааллын хяналтын Улсын байцаагч

Т.Мөнхжаргал Байгаль орчны газрын Байгаль орчны хяналтын Улсын байцаагч

Б.Наранбаатар Байгаль орчны газрын Газар, газрын хэвлий, уул уурхай, тусгай хамгаалалттай газар нутаг, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн

Г.Нансалмаа Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны ахлах мэргэжилтэн

У.Амаржаргал Цагдаагийн газрын Экологийн асуудал хариуцсан эрүүгийн ахлах мөрдөгч, Цагдаагийн хошууч

Я.Дамдинсүрэн Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээллийн ажилтан

Тагнуулын ерөнхий газрын Баянхонгор аймаг дахь хэлтэс


Холбогдох сумдын Засаг дарга, Байгаль орчны хяналтын Улсын байцаагч нар

Нарийн бичгийн дарга:

Г.Энхбаяр Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

_____оОо_____

Аймгийн Засаг даргын 2025 оны 03 дугаар
сарын 24-ны өдрийн 03 дугаар
захирамжийн 03 дугаар хавсралт



**АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ
УДИРДАМЖ**

Нэг.Шалгалтын зорилго, үндэслэл:

Монгол Улсын “Төрийн хяналт шалгалтын тухай”, “Ашигт малтмалын тухай”, “Эрүүл ахуйн тухай”, “Хүнсний аюулгүй байдлыг хангах тухай”, “Ус хангамж ариутгах татуурга ашиглалтын тухай”, “Хог хаягдлын тухай”, “Усны тухай”, “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай”, “Газрын тухай”, “Газрын хэвлийн тухай”, “Авто тээврийн тухай”, “Газрын тосны бүтээгдэхүүний тухай”, “Хөдөлмөрийн тухай”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай”, “Нийгмийн даатгалын тухай”, “Ахмад настны тухай”, “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай” хуулиуд тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, холбогдох норм, стандарт, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын хэрэгжилтэд Төрийн хяналт, шалгалтын тухай хуульд заасан нийтлэг эрх, үүргийн хүрээнд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, цаашид авах арга хэмжээний санал боловсруулахад шалгалтын зорилго оршино.

Хоёр.Шалгалтын төрөл

Төлөвлөгөөт бус шалгалт

Гурав. Шалгалтын арга, хэлбэр

Улсын (ахлах) байцаагч нар хяналтын чиглэл тус бүрээр баримт бичгийг хянан үзэх, газар дээр нь хяналт шалгалт хийж, хяналтын хуудсаар эрсдэлийг үнэлэх, шалгалтын үйл ажиллагааны явц болон илэрсэн зөрчил, дутагдлыг фото зураг авах, дүрс бичлэг хийх, баримт бичгийг хуулбарлан баталгаажуулах, шаардлагатай тохиолдолд бараа бүтээгдэхүүн, орчноос дээж авч лабораторийн шинжилгээнд хамруулах зэрэг аргаар хийж гүйцэтгэнэ.

Дөрөв.Шалгалтын хүрээ, шалгалтад хамрагдах аж ахуйн нэгж, байгууллага, иргэн объектын нэр

Шинэжинст сумын нутагт орших MV-021444 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Эрдэнэ Монгол” ХХК, MV-012728, MV-017057, MV-017060, MV-017061, MV-017062, MV-021487, MV-021488 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Сэкер ресорсус монголиа” ХХК, Баян-Овоо сумын нутагт орших MV-006720, MV-006907 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Наранмандал Энтерпрайзес” ХХК болон тэдгээрийн туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүд, тусгай зөвшөөрлийн талбай

Тав.Шалгалтын бүрэлдэхүүн, ажлын хэсгийн ахлагч

Аймгийн Засаг даргын орлогч Б.Наранбаяраар ахлуулсан тус захирамжийн нэгдүгээр хавсралтаар батлагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Зургаа.Шалгалтын эхлэх болон дуусах хугацаа

Шалгалтыг 2025 оны 03 дугаар сарын 24-ноос 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн хооронд хийж гүйцэтгэнэ.

Долоо.Хяналт шалгалт хийх чиглэл, хамрах хүрээ, хяналтын хуудас

Хяналт шалгалтыг удирдамжид тусгагдсан асуудлын хүрээнд холбогдох хуульд нийцүүлэн хийж гүйцэтгэх ба аж ахуйн нэгж байгууллагуудыг хяналтын хуудсуудаар шалгаж, эрсдэлийг тодорхойлох, бууруулах, таслан зогсоох, зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээг авч, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллах ба дараах эрх бүхий байгууллагын баталсан удирдамж, хяналтын хуудсуудаар шалгана. Үүнд:

-Геологи, уул уурхайн хяналтын чиглэлээр: 6.1. кодтой “Ил уурхайн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас”, 6.8. кодтой “Маркшейдерийн ажлыг шалгах хяналтын хуудас”,

-Хөдөлмөр, хөдөлмөрийн аюулгүй байдлын хяналтын чиглэлээр: 07.1.1. кодтой “Хөдөлмөрийн харилцааг шалгах хяналтын хуудас”, 07.1.2. кодтой “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг шалгах хяналтын хуудас”

-Авто зам, тээврийн хяналтын чиглэлээр: 4.1.19. кодтой “Ачаа тээвэрлэлтийн аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас”, 4.2.3. кодтой “Авто зам, замын байгууламжийн барилга угсралтын шинэчлэлтийг шалгах хяналтын хуудас”

-Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын чиглэлээр: 10.12.1. кодтой “Хоол үйлдвэрлэлийн эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг шалгах хяналтын хуудас”

-Хүнсний чанар, стандартын хяналтын чиглэлээр: 8.10.2. кодтой “Нийтээр нь үйлчлэх хоол үйлдвэрлэлийг шалгах хяналтын хуудас”

-Газрын хяналтын чиглэлээр: 35.2. кодтой “Хот тосгон, бусад суурин газарт газар өмчлөгч, эзэмшигч ашиглагч иргэн аж ахуйн нэгж, байгууллагыг шалгах хяналтын хуудас”

-Байгаль орчны хяналтын чиглэлээр: 01.1.4. кодтой “Үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх байдлыг шалгах хяналтын хуудас”

-Нийгмийн хамгааллын хяналтын чиглэлээр: 07.3.1 кодтой “Ажилтны нийгмийн хамгааллыг шалгах хяналтын хуудас

-Аймгийн Засаг даргын захирамж, албан бичгээр хүргүүлсэн чиглэлийн хэрэгжилт

Найм.Шалгалтын дүнг танилцуулах

1.Шалгалтын дүнг аймгийн Засаг даргад танилцуулж гарсан шийдвэр, өгөгдсөн үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

2.Хяналт шалгалтын дүнг шалгуулагчид танилцуулж илэрсэн дутагдлыг арилгуулахаар хугацаатай үүрэг өгч биелэлтэд хяналт тавьж ажиллана.

Ес.Өмнө хийсэн хяналт шалгалтын талаарх мэдээлэл

Өмнө нь хяналт шалгалт хийгдэж байгаагүй болно.

_____оОо_____